



「АРДЧИЛСАН НАМЫН НАРИЙНТЭЭЛ」  
СУМЫН ХОРООНД

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangaï@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.18 № 288  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「 Хандивын тайлангийн дүгнэлт 」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6 дахь заалтад заасны дагуу Төрийн аудитын байгууллага Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Нарийнтээл сумын хорооны ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Нарийнтээл сумын хороо нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэхь заалт, мөн хуулийн 16 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Хандивын тайлангийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Нарийнтээл сумын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”-ыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

## Дүгнэлт

Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Нарийнтээл сумын хорооны иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланд (тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааны) хандив хүлээн аваагүй байх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Ардчилсан намын Нарийнтээл сумын хорооноос ирүүлсэн хандивын тайланг (.А..хуудас) хавсаргав.

Хувийг: Нарийнтээл сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

Нам, эвслийн нэр: Ардчилсан нам

Д/д	Иргэний нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан			АНСДИТХ-н сонгуулийн тухай хуулийн 53.4-т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн эсэх				Тайлбар
		Иргэний бүртгэлийн дугаар	Нас	Иргэншил	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл			Оршин суугаа хаяг	Утасны дугаар	Огноо	Банкны нэр	Дансны дугаар	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан дансны дугаар	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53, 54, 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана. Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА  
**ХЯНАСАН**  
 БОЛОВСРУУЛСАН:  
 НАМЫН АЖИЛТАН  
**О.ЦЭРЭННАДМИД**

*Handwritten signature*

Нам, эвслэс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

Аймаг, нийслэл. сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

Нам, эвслийн нэр Ардчилсан нам /мян.төг/

Д/д	Иргэний нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл			Хандивын өгсөн огноо АУН	Хандивын мөнгөн	Хандив хүлээн авсан			АНСДИТХ н сонгуулийн тухай хуулийн 53.4-т	Тайлбар				
		Иргэний бүртгэлийн дугаар	Нас	Иргэншил			Хандивын үүсээрийн хаяг	Утасны дугаар	Огноо			Банкны нэр	Дансны дугаар	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан орлого буюу төрийн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

6217143681  
ЙНОА0059 9044094

Санамж Аймаг нийслэл. сум. дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53, 54, 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.



ХЯНАСАН: АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА  
БОЛОВСРУУЛСАН НАМЫН АЖИЛТАН

С.ЦОГБААТАР  
О.ЦӨРЭННАДМИД

*Handwritten signature*